



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № 129 / 2022

2022 оны 11 р сарын 30

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө/цаашид захиалагч гэх/нөгөө талаас Цахим далай ХХК-ийн захирал М.Анумарал /цаашид гүйцэтгэгч гэх/хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1 Гэрээний зорилго нь “**Вагон жингийн программ суулгах**” ажлыг дор дурдсан хугацаанд гүйцэтгэж захиалагч талд хэвийн үйл ажиллагааг хангаж хүлээлгэж өгөх, Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг дүгнэж зохих шаардлагыг хангасан гэж үзвэл энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд ажлын хөлсийг төлөх, харилцан үүрэг хүлээх, хариуцлагыг тогтоох, ажил эхлэх, гүйцэтгэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл , ерөнхий зүйл, хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь “Вагон жингийн программ суулгах ” (цаашид “ажил” гэх) -ыг энэхүү ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр дуусгах ба 3 /гурав/ хоногт багтаан гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь **Uniwei gh 4.2** программ суулгаж өгнө. Компанийн горим ажиллагаатай холбоотойгоор эхлэх өдрийг мөрдөх боломжгүй болсон бол наряд нээгдсэн өдрөөр тооцож болно.

Гурав. Төлбөр тооцоо

3.1 Гэрээт ажлын үнэ нь 2,000,000 /хоёр сая/ төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. НӨАТ ороогүй үнэ болно.

3.2 Гэрээт ажилд урьдчилгаа төлбөр төлөхгүй. Гэрээт ажлын төлбөрийг гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 30 хоногийн дотор багтаан гүйцэтгэгчийн Голомт банкны 1415141789 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гэрээт ажлыг гэрээний үнэд багтаан батлагдсан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2 Гэрээ дүгнэснээс хойш нэг жилийн хугацаанд программ дээр алдаа илэрч, шаардлага хангахгүй нөхцөл үүссэн тохиолдолд шинэ хувилбарыг үнэ төлбөргүй суурилуулж өгнө.

- 4.3 Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ажилтнуудаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангуулж, цахилгааны болон галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч ажиллах ба эдгээр шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн шаардлагаар ажлыг зогсооно.
- 4.4 Ажил гүйцэтгэх хугацаанд Эрчим хүчний системд мөрдөгдөж буй ТАД, ААД болон холбогдох бусад дүрэм журмыг мөрдөж ажиллана. Захиалагчийн тавьсан хууль ёсны шаардлага зөвлөмжийг заавал биелүүлнэ. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэсний дараа доорх баримт бичгийг бүрдүүлнэ. Гэрээний үнэд багтаан захиалагч программтай холбоотой нэмэлт ажил гүйцэтгүүлж болно. Үүнд:

Ажил гүйцэтгэлийн тайлан	4хувь
Гарын авлага, install,	3хувь

- 4.5 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай автомашин, техник, багаж, тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуул хамгаалалтын ажилтанд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.6 Гүйцэтгэгч тал захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй
- 4.7 Ажил гүйцэтгэгч компани нь уг ажлыг гүйцэтгэх явцад нарядын системийг чанд мөрдөнө.
- 4.8 Ажил үйлчилгээг нэгэнт эхэлснээс хойш гэрээг цуцлах санал тавихгүй.
- 4.9 Ажил гүйцэтгэгч нь станцын хашаанд нэвтрэх бичиг авч, захиалагчийн дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөн ажиллана. Захиалагч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1 ХАБ,ААД-ийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан эсэргүүцсэн, дүрэм стандартыг зөрчсөн чанарын гологдол гаргасан тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах эрхтэй.
- 5.2 Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл, доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 5.3 Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь ажлын комисс хүлээн авна.
- 5.4 Ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд захиалагч талаас хяналтыг тогтмол тавьж ажиллана.
- 5.5 Захиалагч талаас гэрээний үнийн дүнг өөрчлөхгүйгээр зарим нэгэн ажил, ажлын тоо хэмжээнд гүйцэтгэгчтэй тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

Зургаа. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- 6.1 Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %-иар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.2 Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 % -ийн алданги хүлээх ба үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 6.3 Нэг жилийн дотор гүйцэтгэсэн ажлын чанар, программтай холбоотой техникийн доголдол, алдаа гарвал захиалагч нь мэдсэн өдрөөс хойш гүйцэтгэгчид мэдэгдэж гүйцэтгэгч нь ажлын 5 хоногийн дотор өөрсдийн хөрөнгөөр засаж хэвийн ажиллагаанд оруулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

- 6.4 Компанийн дотоод дүрэм, журам зөрчих, ажлын байранд ёс бус үйл ажиллагаа явуулах согтууруулах ундаа авчирсан, уусан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээг цуцлах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхөөс татгалзана.
- 6.5 Алданги төлсөн нь үндсэн үүрэг болон учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.6 Захиалагчийн саналаар нэмэлт ажил хийгдэх, үнийн ямар нэгэн зөрүү гарсан тухай бүр 2 /хоёр/ тал харилцан тохиролцож акт протоколоор баталгаажуулж шийдвэрлэнэ.
- 6.7 Захиалагчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Түлш дамжуулах цехийн дарга Д.Түвшинзаяа хариуцан ажиллана. Утас-99026048.
- 6.8 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Цахим далай” ХХК-ийн захирал М.Анумарал хариуцан ажиллана. Утас-89116695.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх газар хөдлөх, зуд болох, тахал болон байгалийн бусад хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт импортын хориг ажил хаялт үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 7.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй болсон бол талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээт хугацаан дээрх нөхцөл байдал арилгах хүртэл хугацаагаар сунгагдах буюу нэг талын санаачилгаар цуцална.
- 7.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Найм. Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах

- 8.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ талууд ноцтой зөрчсөн буюу хуульд заасан үндэслэл бий болсон бол талууд хэдийд ч гэрээг цуцлах эрхтэй.
- 8.2 Хэрвээ талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал урьдчилан тохиролцон хавсралтаар оруулж гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар гэрээний нэгэн адил хууль зүйн хүчинтэй.
- 8.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил гүйцэтгэх хугацаа хожимдуулсан, ноцтой зөрчил гаргасан цаашид уг ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг цуцална.

Ес. Бусад зүйл

- 9.1 Энэхүү гэрээний үйлчлэл нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, талууд тус тусын үүргээ биелүүлж баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

9.6 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР



Э.МӨНХЖАРГАЛ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“ЦАХИМ ДАЛАЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



М.АНУМАРАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ



Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.БАТТУЛГА

ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА



Д.ТҮВШИНЗАЯА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.ГАНТУЛГА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

Хаяг: СБД 9-р хороо Шинэ дэлхий 302 тоот
Утас: 89891718, 89113395.
РД: 6609619